



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/10

Модот

“Нэг зорилго - Илүү бүтээмж” уулзалт
зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Сумын төрийн албан хаагч нарын дунд “Нэг зорилго - Илүү бүтээмж”-ийн уулзалт, ярилцлагыг 2026 оны 02 дугаар сарын 06-ний өдөр зохион байгуулж явуулсугай.

2. Уг уулзалт, ярилцлагыг зохион байгуулж явуулах, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: Ү.Ичинхорлоо - Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга 3.Энхбямба - Улсын бүртгэгч
Гишүүдэд Д.Өсөхгэрэл - Мал үржүүлэг, технологийн ажил
үйлчилгээний хяналтын улсын байцаагч
И.Найманцэцэг - Нийгмийн бодлогын асуудал
хариуцсан мэргэжилтэн
М.Ганчимэг - Нийгмийн даатгалын байцаагч

3. Уулзалтанд ашиглах техник хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, уулзалт зохион байгуулах байрны орчин нөхцөлийг сайтар бүрдүүлж, Төрийн албан хаагч нарын хэрэгцээ шаардлагад нийцсэн сэдэвүүдээр зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Ү.Ичинхорлоо), нийт томилогдсон гишүүдэд үүрэг бологсугай

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ